



МОНГОЛ УЛС
ХЭНТИЙ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2017 оны 04 сарын 04 өдөр

Дугаар 4/143

Хэрлэн сум

Эрх шилжүүлэх тухай

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.2, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 45 дугаар зүйлийн 45.6 дахь хэсэг, Барилгын тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.5, 4.1.28 дахь заалт, 23 дугаар зүйлийн 23.3.2 дахь заалт, 24 дүгээр зүйлийн 24.1.1 дэх заалт, 25 дугаар зүйлийн 25.8 дахь хэсэг, Монгол Улсын Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын сайдын 2017 оны 03 дугаар сарын 16-ны өдрийн А/89 дүгээр тушаалыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Монгол Улсын Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын сайдын А/89 дүгээр тушаалаар батлагдсан 2017 онд хэрэгжих Хэнтий аймгийн Баян-Овоо сумын сургуулийн барилгын засварын ажлын худалдан авах ажиллагааны захиалагчийн эрхийг Баян-Овоо сумын Засаг даргын Тамгын газарт шилжүүлсүгэй.

2. Тус ажлын худалдан авах ажиллагааг батлагдсан төсөвт өртөгт багтаан Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан тухай хуулийн дагуу зохион байгуулж, тайлагнахыг Баян-Овоо сумын Засаг даргын Тамгын газрын даргад үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА



Н.ГАНБЯМБА

01 695